

## МОНГОЛ УЛСЫН НИЙГМИЙН СҮЛЖЭЭНИЙ ХУУЛЬ

### ОРШИЛ

Монгол Улсын Их Хурал 2023 оны 1-р сарын 23-ны өдөр “Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль” (цаашид Олон нийтийн сүлжээний хууль гэх)-ийг батлав. Хуулийг өргөн барьснаас хойш гурав хоногт хэлэлцэн баталсан нь “Ковид”-ын хуулийг яаравчлан баталсан хугацаанаас ч ахархан байгаа нь юуны өмнө анхаарал татна. Олон нийтийн сүлжээний хууль нь 2023 оны 2-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхлэх байсан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх 2023 оны 2-р сарын 27-нд (уг хууль болоод түүнийг дагалдах дөрвөн хуульд тусах нэмэлт, өөрчлөлтөд<sup>1</sup>) хориг тавиад байна.

Ерөнхийлөгчийн хоригт дээрх хуулийг боловсруулж гаргах үйл явцад “олон нийтийн оролцоог хангаагүй, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийн саналыг аваагүй” болохыг тэмдэглэжээ. Иймд хууль тогтоох үйл явц нь Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчих нөхцөлийг бий болгосон байгааг онцолсон байна. Ерөнхийлөгч хуульд хориг тавьсан талаарх мэдэгдэлд хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн болохыг дурдаад, “хууль тогтоомжийг боловсруулах, хэлэлцэн батлахдаа олон нийтийн оролцоог сайтар ханган, мэргэжлийн болон судалгааны байгууллагын санаа бодлыг сонсож байх учиртай”-г дурджээ.<sup>2</sup> Ерөнхийлөгч хоригтоо хууль тогтоох үйл явц дахь иргэдийн оролцоог ийнхүү чухалчлан авч үзсэн нь ардчиллын зарчмуудтай холбоотой олон улсын эрх зүйн тогтсон уламжлал болох төрийн үйл хэрэг явуулах, бодлого боловсруулахад иргэдийн оролцоог хангах зарчимтай агаар нэг байна.

Ерөнхийлөгч хориг тавьсантай холбоотой УИХ нь Олон нийтийн сүлжээний хуулийн талаар дахин хэлэлцэж хоригийг хүлээн авах эсэх асуудлаар шийдвэр гаргана.

Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (АТБХОУТ) нь Монгол дахь хамтын ажиллагаа бүхий байгууллагаас хуулийн албан бус орчуулгыг хүлээн авч тэдний хүсэлтээр дараах товч дүн шинжилгээг бэлтгэн танилцуулж байна. Энэхүү дүн шинжилгээнд хуультай холбоотой бүх асуудлыг хамруулан авч үзээгүй бөгөөд зөвхөн анхаарал татаж буй гол асуудлуудыг онцолсон болохыг дурдах нь зүйтэй.<sup>3</sup>

1 Харилцаа Холбооны тухай хууль, Кибер Аюулгүй Байдлын тухай хууль, Хүний Хувийн Мэдээлэл Хамгаалах тухай хууль, Татварын Ерөнхий хууль

2 <https://montsame.mn/en/read/312102>

3 Дүн шинжилгээтэй холбоотой асууж тодруулах зүйл байх аваас [asia@icnl.org](mailto:asia@icnl.org) цахим шуудангаар холбогдох боломжтой

## ДҮН ШИНЖИЛГЭЭ

Олон нийтийн сүлжээний хууль, дагалдах хуулийн нэмэлт, өөрчлөлтүүд нь батлагдан хэрэгжих аваас иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болоод тайван жагсаал цуглаан хийх эрх зөрчигдөх эрсдэл үүсэхээр байна. Өргөн цар хүрээ хамрах категорит багтах цахим контентыг хориглохоор заасны зэрэгцээ олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгчид хандсан зохицуулалт нь хэтийдсэн, хувийн нууц, нэрээ нууцлахтай холбоотой стандартуудыг зөрчсөн, төрийн байгууллагад контентыг цагдан хянаж, харилцаа холбооны сүлжээг хязгаарлах (тухайлбал, интернетийн хурдыг сааруулах буюу зогсоох асуудал багтана) эрх олгосон байна.

### *Тодруулбал, хууль нь:*

Оновчгүй, ерөнхий тодорхойлсон категориор мэдээллийг цагдан хянахаар байна:

- Хуулийн 6 дугаар зүйлд зөрчилтэй контентын олон хэлбэрийг тусгасны дотор “Монгол Улсын төрийн бэлгэ, тэмдгийг гутаан доромжилсон”, “хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан”, “экстремист үйл ажиллагаа”, “үндэсний эв нэгдлийг бусниулах” гэх мэтчилэн заажээ.

Ийнхүү тоочихдоо “экстремист үйл ажиллагаа” гэж юуг хэлэх, чухам юуг “үндэсний эв нэгдлийг бусниулах” гэж ойлгох талаар тодорхой тусгаагүй байна. Хүүхдийг хамгаалах нь чухал асуудал боловч чухам юуг “хүүхдийн оюун санаанд сөргөөр нөлөөлөхүйц” зүйл сурталчилж байна гэж үзэх нь ойлгомжгүй. Жишээ нь: видео тоглоом сурталчлахыг тооцох уу? Түүнчлэн, улсын гадаад худалдааны бодлогыг шүүмжилсэн пост Фейсбүүкт нийтэлснийг аль нэг албан тушаалтан “үндэсний эв нэгдлийг бусниулах” агуулга гэж үзэж болохын зэрэгцээ байгаль орчныг хамгаалах асуудлаар Твиттерт жиргэснийг “экстремист үйл ажиллагаа” ч гэж тайлбарлах бололцоотой.

Дарангуйлагч дэглэмтэй улсуудад дээрх шиг хэт ерөнхий агуулга бүхий заалтыг ашиглаж нийгмийн аливаа асуудлаарх маргаан мэтгэлцээнийг хянах, нийгмийн сайн сайхны төлөө зүтгэж буй хүний эрхийн хамгаалагчид, иргэний нийгмийн идэвхтнүүдийг цагдан хорих хэрэгсэл болгох нь олонтоо. Хэт өргөн бөгөөд бүрхэг агуулга бүхий ийм заалтууд нь цахим орчинд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг субъектив байдлаар дур мэдэн хязгаарлах хийдлийг бий болгох бөгөөд олон улсын холбогдох эрх зүйн актуудтай зөрчилдөж байна.

Цахим үйлчилгээ эрхлэгчдэд хамаарах зохицуулалт нь хэтийдсэн, иргэний орон зайг хязгаарлахаар байна:

- Хуулийн 7 дугаар зүйлээр үйлчилгээ эрхлэгчид “зөрчилтэй контент, эсхүл зөрчилтэй контент агуулсан хэрэглэгчийн мэдээллийг гаргуулах” талаар олон нийттэй харилцах нэгжийн хүсэлт, шийдвэрийг хүлээн авч, хянан шийдвэрлэх, хаягийг түдгэлзүүлэх, устгах, “мэдээллийн тархцыг бууруулах” гэх мэт үүргийг ногдуулсан байна.

Олон улсын холбогдох эрх зүйн актын дагуу цахим платформуудтай холбоотой ийм

хэтийдсэн арга хэмжээ нь цахим үйлчилгээ эрхлэгчдийн хариуцлагатай холбоотой стандартуудтай зөрчилдөж байна. Тухайлбал, платформын засаглалтай холбоотой дараах зарчмууд үйлчилдэг. Үүнд:

1. Гуравдагч этгээдийн контентын улмаас хариуцлага тулгахгүй байх
2. *Шүүхийн эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр* контентыг аливаа байдлаар хязгаарлахгүй байх
3. Контентыг хязгаарлах хүсэлт нь *тодорхой, хоёрдмол утгагүй, зохих хуульд заасан процессын дагуу байх*
4. Хууль, контент хязгаарлахад баримтлах бодлого, арга хэмжээ нь *зайлшгүй хэрэгцээтэй, зохих тэнцвэрийг* хангасан байх
5. Хууль, контент хязгаарлахад баримтлах бодлого, арга хэмжээ нь *зохих процессыг баримталсан байх,*
6. Хууль, контент хязгаарлахад баримтлах бодлого, арга хэмжээнд *ил тод байдал, хариуцлагыг заавал тусгах.*<sup>4</sup>

Олон нийттэй харилцах нэгж нь үйлчилгээ үзүүлэгчээс ямар ч мэдээллийг шаардаж авах эрх олгосон нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй том, жижиг цахим платформ, үйлчилгээ эрхлэгчид, зуучлагчдад болгоомжлол үүсгэж, улмаар иргэний болон бизнесийн цахим орон зай хумигдахад нөлөөлөх бололцоотой.

- o Түүнчлэн хуулийн 4 дүгээр зүйлд “олон нийтийн сүлжээ” болон “үйлчилгээ эрхлэгч” гэдгийг хэт ерөнхий тодорхойлсон байх бөгөөд үүнээс үүдэн хууль нь олон янзын хэрэглэгч, хуулийн этгээдэд хамаарч үйлчлэхээр байна. Үйлчилгээ эрхлэгчийг “олон нийтийн сүлжээний үйлчилгээ үзүүлж буй этгээд,” түүнчлэн олон нийтийн сүлжээг “интернэт сүлжээ ашиглан контентыг нийтэд нийтлэх, түгээх, харилцан мэдээлэл солилцох зориулалт бүхий программ хангамжийг” хэлнэ гэж тус тус тодорхойлсноор олон тооны этгээд (үүнд *магадгүй хуулийн зорилгод анхнаасаа хамаагүй байсан талууд*) хамаарахаар байна.

Тухайлбал, коммент бичих бололцоотой хоолны блогт контентыг нийтэд нийтлэх, харилцан мэдээлэл солилцох зориулалт бүхий программ хангамжийг ашигласан байж болно. Түүнчлэн уншигч коммент бичих бололцоотой, бусад интерактив үйлчилгээ бүхий цахим сонин мөн үүнд орно. Автоматаар олон хэрэглэгчид цахим шуудан илгээх программ хангамж ашигладаг их, дээд сургууль, аж ахуйн нэгж ч үйлчилгээ эрхлэгчийг тайлбарласан дээрх томъёололд багтахар байна. Хуулийн 7-р зүйлийн дагуу эдгээр этгээд Олон нийттэй харилцах нэгжийн хүсэлтийн дагуу арга хэмжээ авч, жилийн тайлангаа хүргүүлэх, хэрэглэгчийг бүртгэх зэрэг үүрэг хүлээх болж байна.

---

4 Зуучлагчдын хариуцлагын талаарх Манилагийн зарчим, 2015 оны 03 сарын 24, EFF, [https://www.eff.org/files/2015/10/31/manila\\_principles\\_1.0.pdf](https://www.eff.org/files/2015/10/31/manila_principles_1.0.pdf), онцлон тэмдэглэв.

Хүний хувийн нууц, нэрээ нууцлах эрхэд халдаж, төрийн тагнаж хянах арга хэмжээг өөгшүүлсэн шинжтэй байна:

- Хуулийн 7 дугаар зүйлд зааснаас үзвэл “үйлчилгээ эрхлэгч” нь хэрэглэгчийн мэдээллийг гаргуулах асуудлаар Олон нийттэй харилцах нэгжийн хүсэлт, шийдвэрийг хүлээн авч, хянан шийдвэрлэхийн сацуу хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах үүргийг мөн давхар хүлээж байна. Олон нийттэй харилцах нэгжийн хүсэлтийг хүлээн авч хангаж шийдвэрлэх нөхцөлд “хэрэглэгчийн хувийн мэдээллийг хамгаалах” үүрэг хэрхэн хэрэгжих нь ойлгомжгүй. Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хууль нь зарим талаар асуудалтай, хувийн мэдээллийг хамгаалах, ил тод байдлыг хангах талаар хэрэгжүүлж ирсэн арга хэмжээний үр дүн нь Монгол Улсад алаг цоог байж ирснийг бодолцож үзэхэд интернет хэрэглэгчийн хувийн орон зай, мэдээлэл хангалттай хамгаалагдах баталгаа байхгүй байна.
- Хуулийн 9 дүгээр зүйлийн хүрээнд хүн, хуулийн этгээд зөрчилтэй контентын талаар Олон нийттэй харилцах нэгжид хүсэлт гаргах боломжтой байхаар зохицуулжээ. Энэ нь цаашлаад хүний эрхийг хамгаалагчид, иргэний нийгмийн идэвхтнүүдийн хувийн мэдээллийг илчлэх, хүнийг шууд болон шууд бусаар тодорхойлох, эсхүл тодорхойлох боломжтой бусад мэдээллийг задруулах эрсдэлийг бий болгож байна. Тухайлбал, орон нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг томоохон компани гол ус бохирдуулж буй талаар нутгийн иргэд олон нийтийн сүлжээнд шүүмжилсний хариуд компанийн эзэн “экстремист үйл ажиллагаа” явуулаа, хөгжлийн төсөлд саад учруулж “үндэсний эв нэгдлийг бусниулах” зүйл хийлээ гэж Олон нийттэй харилцах нэгжид хүсэлт гаргах бололцоотой байна. Улмаар шүүмжлэл бичсэн иргэдийн хувийн мэдээлэл задрах нөхцөлд хүргэх эрсдэл харагдаж байна.

Цахим орчинд нэр, нүүрээ нууцлах, үүнд нууц нэр ашиглах нь нийгмийн харилцааны зүй ёсны хамгаалалтын механизм юм.

Нэр нүүрээ нууцлах нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, хувийн мэдээллээ нууцалж хамгаалах, улс төрийн хариуцлага, иргэдийн оролцооны чухал бүрэлдэхүүн хэсэг болохыг олон улсад нэгэнт хүлээн зөвшөөрөх болсон.

- Тус хуулийг дагалдуулан Кибер аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд Олон нийтийн сүлжээний хуульд заасан зөрчилтэй контентыг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээ авах буюу харилцаа холбоо, мэдээллийн сүлжээнд хяналт тавих эрхийг төрийн байгууллагад олгох агуулгатай зохицуулалт тусжээ. Энэ заалт нь хүний хувийн захидал харилцааг төр дур зоргоороо хянахгүй гэх баталгаа буюу хүний эрхийн тодорхой хамгаалалтгүйгээр хяналтыг өөгшүүлсэн шинжтэй байна. Контентыг хязгаарлах үндэслэл болох “үндэсний эв нэгдлийг бусниулах” гэх мэт өргөн хүрээг хамрах категорийг ашиглан төр нь хувь хүний захидал харилцааны нууцад нэвтрэх, хянах бололцоог нээж байна.
- Эдгээр заалтыг хэрэгжүүлснээр иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, хувийн мэдээллээ нууцлах, хамгаалах эрхийн ноцтой зөрчил үүсэж болохоор байна.

Интернет, холбоо харилцааны сүлжээг тодорхой хязгаар тавилгүй саатуулах хязгаарлах нөхцөл үүсэхээр байна:

- Хуулийг дагалдуулан Харилцаа Холбооны тухай хуульд тусгах нэмэлт өөрчлөлтийн хүрээнд Кибер Аюулгүй Байдлын зөвлөлд “нийтийг хамарсан үймээн самуун дэгдсэн тохиолдолд” “нийтийн сүлжээний холбоо харилцааг бүрэн эсхүл хэсэгчлэн хязгаарлах” эрх олгосон байна. Энэ нь интернет болон бусад хэлбэрийн харилцаа холбоог хуулиас гадуур дур мэдэн зогсоох, зарим цахим хуудсыг хаах, интернет дамжуулалтын хурдыг сааруулах гэх мэт ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй юм.

“Нийтийг хамарсан үймээн самуун” нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх болоод тайван жагсаал цуглаан хийх эрхийг зөрчих шалтгаан болох учиргүй юм. Ялангуяа, харилцаа холбооны хэрэгслүүд нь өнөөгийн нийгэмд өдөр тутмын хэрэгцээ болоод зогсохгүй амьд явах эрхээ хангахад ашиглагдах нь бий. Олон нийтийн сүлжээ нь иргэний нийгмийн активизмд чухал үүрэгтэй бөгөөд интернетийг, харилцаа холбоог хязгаарлах нь иргэдийн тайван жагсаал цуглаан хийх эрхэд халтай. НҮБ-ын Хүний Эрхийн зөвлөл, Хүний Эрхийн хороо зэрэг олон улсын байгууллагуудаас интернет ашиглах нь хүний эрх болохыг хүлээн зөвшөөрч, зөвхөн онцгой нөхцөл байдлын үед тухайн үүссэн нөхцөлд тохирсон байдлаар хязгаарлахыг сануулдаг. Түүнчлэн олон улсын эрх зүйн хүрээнд мэдээлэл, харилцааны сүлжээг өргөн хүрээнд хязгаарлах явдлыг хууль бус гэж үзэх нь давамгайлдаг. Иймд энэхүү нэмэлт өөрчлөлт нь олон улсын хууль тогтоомжид нийцэхгүй байна.

Хуулийн төсөл нь ийм байдлаар хүний үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хумиад зогсохгүй олон нийтийн нийгмийн сүлжээ, тэдгээрийн баримталдаг дүрмүүдтэй нь зөрчилдсөн болон олон улсын хуулийг зөрчих магадлалтай маш олон зүйл заалтууд байна.

## **ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН АКТУУД**

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭтОУП), Эдийн засаг, Нийгэм, Соёлын эрхийн тухай олон улсын пакт (ЭЗНСЭтОУП) зэрэг бусад олон хүний эрхийн конвенц, тунхаглалуудаар баталгаажиг хамгаалагдсан эрх юм. Монгол Улс 1974 онд ИБУТЭтОУП, ЭЗНСЭтОУП –ыг соёрхон баталсан. Түүнчлэн, Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц (АҮАҮБХУтОУК), Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (ЭАБХУтК), Хүүхдийн эрхийн тухай конвенц (ХЭтК), Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай конвенц (ХБХтК)-уудыг тус тус соёрхон баталжээ. Эдгээр бүх олон улсын гэрээ нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөөтэй холбогдох эрхүүдийг тусган хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ хүний хувийн нууцыг хамгаалах эрх гэх мэт бусад үндсэн эрх, эрх чөлөөг мөн баталгаажуулсан байдаг.

Цаашилбал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт (ИБУТЭтОУП)-ын 19 дүгээр зүйлд тус пактад нэгдэн орсон улсуудын төр засаг нь мэдээллийг улсын хил хязгаар үл харгалзан хүлээн авах, хуваалцах эрх чөлөө болон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалахыг үүрэг болгожээ. НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос “аливаа цахим хуудас, блог эсвэл бусад интернетэд суурилсан цахим мэдээлэл, мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлэл тараахыг хязгаарласан бол дээрх пактын 19 дүгээр зүйлийг мөрдөнө” гэж тодорхой дурдсан байдаг<sup>5</sup>.

19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хязгаарлах бол гагцхүү дор дурдсан гурван хэсгээс шалгуурыг бүгдийг хангасан тохиолдолд хууль ёсны гэж үзэх бололцоотой.<sup>6</sup> Үүнд:

1. хязгаарлалтыг хуулиар тогтоох ба хүн бүрд тодорхой ойлгогдохуйц, хүртээмжтэй байх (дур зоргын бус, тодорхой, ил тод байх зарчмууд);
2. хязгаарлалт нь ИБУТЭтОУП-ын 19 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зорилгын аль нэгийг хангаж байх шаардлагатай, тухайлбал: (i) бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх/хамгаалах; (ii) үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах (хууль ёсны байх зарчим); болон
3. хязгаарлалт нь зайлшгүй шаардлагатай бөгөөд тодорхой зорилгыг биелүүлэхэд шаардагдах хязгаарлалт хамгийн бага түвшинд байх (хэрэгцээ шаардлага болон нөхцөл байдалд тохирсон байх зарчмууд).

Дээрхээс гадна хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай асуудал нь ИБУТЭтОУП-ын 17 дугаар зүйлд туссан эрх юм: 1. *Хэний ч хувийн болон гэр бүлийн амьдралд хөндлөнгөөс дур мэдэн буюу хууль бусаар оролцох, орон байранд нь буюу захидал харилцааных нь нууцад дур мэдэн буюу хууль бусаар халдах, эсхүл нэр төр, алдар хүндэд нь хууль бусаар халдахыг хориглоно.* 2. *Хүн бүр тийм оролцоо, халдлагаас хуулиар хамгаалуулах эрхтэй.* Хувийн мэдээллээ хамгаалуулах эрх нь хувь хүмүүс төрийн хөндлөнгийн оролцооноос ангид “хувийн орон зай”-д чөлөөтэй харилцах тухай ойлголтод үндэслэдэг.<sup>7</sup> НҮБ-ын Хүний Эрхийн Хорооноос харилцаа холбооны нууцаа хамгаалах эрхээ хэрэгжүүлэхийн тулд хүн мэдээллээ илчлэхгүй байх, хамгаалах, түүнчлэн хүсвэл нэрээ нууцлах эрхтэй болохыг хүлээн зөвшөөрчээ.<sup>8</sup>

5 Хүний эрхий хороо, Ерөнхий тайлбар №34: 19 дүгээр зүйл: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, 43-р хэсэг, НҮБ-ын бичиг баримт # CCPR/C/GC/34 (2011). Хүний Эрхийн Хороо, Ерөнхий тайлбар No. 34: 19 дүгээр зүйл: Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, 43 дах хэсэг, UN Doc # CCPR/C/GC/34 (2011).

6 НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл A/HRC/17/27, “НҮБ-ын тусгай илтгэгч Фрэнк Ла Руи-ийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар тавьсан илтгэл” 2011 оны 05 сарын 16, 69 дэх хэсгийг харна уу.

7 Лорд Лестер, Д.Пэнник (ред.).Хүний Эрхийн Хууль ба Практик. Лондон, 4.82 дах хэсгийг харна уу. (Butterworth, 2004).

8 НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, A/HRC/23/40, НҮБ-ын тусгай илтгэгч Фрэнк Ла Руи-ийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар тавьсан илтгэл” 2013 он 4 сарын 17. 23 дах хэсгийг харна уу.

Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 17-р зүйлд тусгасан хувийн нууц, халдашгүй байх эрхэд зайлшгүй бөгөөд хууль ёсны, тохирох хязгаарлалтыг тавьж болох санаа агуулагдаж байдаг ба НҮБ-ын үзэл бодлоо илэрхийлэх эрхийн асуудлаарх Тусгай илтгэгч (Тусгай илтгэгч)-ийн илтгэлд хувийн нууцтай холбоотой эрхэд тавигдах хязгаарлалт нь Хүний эрхийн хорооны Ерөнхий тайлбар 27, 15-р зүйлд дурдсан чөлөөтэй хөдөлгөөн хийх эрхэд тавигддаг хязгаарлалттай адил түвшинд байх нь зүйтэй гэсэн байна. Үүнд:

- (а) Аливаа хязгаарлалт нь хуульд заасан, хуулийн хүрээнд байх;
- (б) Хүний язгуур эрхэд хамаарах эрхийг хязгаарлалтад хамруулахгүй;
- (в) Аливаа хязгаарлалт нь ардчилсан нийгэмд зайлшгүй шаардлагатай байх;
- (г) Хязгаарлалтыг хэрэгжүүлэх эрх мэдэлд заавал давхар хяналт тавих;
- (д) Хязгаарлалтын тухайд энэ нь дурдсан хэд хэдэн зорилгын аль нэгэнд хүрэх нь хангалтгүй ба хууль ёсны тодорхой зорилгод хүрэхэд зайлшгүй шаардлагатай байх,
- (е) Хязгаарлалтын арга хэмжээ нь нөхцөл байдалд тохирсон байх зарчимд нийцсэн, өөрөөр хэлбэл хамгаалах үүргээ хэрэгжүүлэхэд тохирсон байх, боломжит шийдлийн хувилбарууд дотроос хүний хувийн мэдээлэлд хамгийн бага халдах, хамгаалах ёстой ашиг сонирхолд тохирсон байх гэх мэт болно<sup>9</sup>.

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хувийн мэдээллээ хамгаалуулах эрх нь харилцан холбоо бүхий эрхүүд бөгөөд “хувийн мэдээллээ хамгаалуулах эрх нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хэрэгжилтэд шаардагдах чухал нөхцөл болдог”.<sup>10</sup> Эдгээр эрхийн аль нэгийг хязгаарлахад нөгөө эрх нь хөндөгддөг. ИБУТЭтОУП-ын 19 дүгээр зүйлийн хүрээнд гурван бүрэлдэхүүн хэсэг бүхий шалгуурыг бүгдийг хангасан тохиолдолд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хязгаарлалтыг хууль ёсны гэж үзэх боломжтой байдагтай адил хувийн нууцаа хамгаалуулах эрхийн хязгаарлалт нь Ерөнхий Тайлбарын 27 дугаар зүйлд заасан шалгуурыг хангах тохиолдолд л хууль ёсны болох юм<sup>11</sup>.

9 Хүний Эрхийн хороо, Ерөнхий тайлбар No. 27: Чөлөөтэй хөдөлгөөн хийх эрх (12-р зүйл), 15 дах хэсэг, UN Doc # CCPR/C/21/Rev.1/Add.9 (1999); НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, A/HRC/23/40, “НҮБ-ын тусгай илтгэгч Фрэнк Ла Руи-ийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар тавьсан илтгэл” 2013 он 4 сарын 17, 29 дэх хэсэг.

10 НҮБ-ын Хүний Эрхийн Хороо, A/HRC/23/40, “НҮБ-ын тусгай илтгэгч Фрэнк Ла Руи-ийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөөг хамгаалах асуудлаар тавьсан илтгэл” 2013 он 4 сарын 17, 24 дэх хэсэг.

11 Id. at para. 29.

## ДУГНЭЛТ

Монгол Улс цахим орчинд гарсан болон бусад хэлбэрийн гэмт хэргийг зохицуулсан олон хуультай. Хуурамч мэдээлэлтэй тэмцэх, цахим орчинд хүний эрх зөрчигдөхөөс хамгаалах нь сайшаалтай зорилт хэдий ч чөлөөтэй илэрхийлсэн үзэл бодлыг цагдан хянах, худал, үнэн, ёс суртахууныг шүүх эрхийг улс төрийн оролцогчдод өгөх нь явуургүй. Хууль нь өөрөө хүний эрх, олон улсын гэрээг зөрчих магадлал байхад хуулийн нэрд “хүний эрх” гэж оруулж, олон улсын гэрээ, конвенц давж үйлчлэх талаар дурдаад нэмэр багатай.

Эрүүл саруул цахим орчныг дэмжсэн, ардчилсан мэтгэлцээн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хамгаалсан илүү үр дүнтэй албан бус механизмууд байдгийг санах нь зүйтэй. Тухайлбал, иргэний боловсрол, цахим орчны зохистой хэрэглээг сурталчилж таниулах кампанит ажлууд, хүний эрхийн боловсрол, хараат бус баримт нягтлах сүлжээнүүд, сэтгүүл зүйн ёс зүйн зарчмууд гэх мэт олон хэлбэрийн арга хэмжээг дурдаж болно. Олон улсын эрх зүйн актуудын хүрээнд авч үзэхэд “хуурамч мэдээ” гэх нэрээр мэдээллийг гэмт хэрэгт тооцох, өргөн цар хүрээ бүхий цахим контентыг хууль бус гэж үзэх хууль батлахыг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм.

Цахим орчинд хүний эрхийг хамгаалах асуудлыг үр дүнтэй байдлаар хуульчлах нь нарийн түвэгтэй бөгөөд хүний эрхийн мэргэжилтнүүд, иргэний нийгмийн байгууллагууд болон нийтийн сүлжээний платформуудтай нягт хэлэлцвэл зохилтой. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх олон нийтийн сүлжээний хууль нь үнэхээр зайлшгүй шаардлагатай эсэх, Монгол Улсын Үндсэн хууль болон олон улсын хуультай зөрчилдөж буй эсэх дээр нээлттэй хэлэлцэж, зөвшилцөх хэрэгтэй гэж тэмдэглэсэн билээ.

*Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (АТБХОУТ) нь олон улсын мэргэжилтнүүд, төрийн болон иргэний нийгмийн байгууллагуудад хэрэгтэй нэмэлт мэдээлэл болон техник туслалцаа өгөхдөө бэлэн байх болно.*

2023 оны 2 сар

**ICNL** INTERNATIONAL CENTER  
FOR NOT-FOR-PROFIT LAW

### БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Ашгийн төлөө бус хуулийн олон улсын төв (АТБХОУТ) нь иргэний нийгмийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгож хөгжүүлэхэд дэлхийн улс орнуудад техникийн туслалцаа, судалгаа шинжилгээ, боловсролын дэмжлэг үзүүлдэг олон улсын байгууллага юм. АТБХОУТ нь дэлхийн 100 гаруй оронд хийгдсэн иргэний нийгмийн эрх зүйн шинэчлэлд туслалцаа үзүүлээд байна. АТБХОУТ нь олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, хувийн сангууд болон дотоодын байгууллагуудтай нягт хамтран ажилладаг. Бидний үйл ажиллагааны талаарх илүү дэлгэрэнгүй мэдээллийг [www.icnl.org](http://www.icnl.org)-оос үзэх боломжтой.

Энэ удаагийн “Хуулийн шүүмж”-ид АТБХОУТ-өөс 2023 оны 2 сард гаргасан Монгол Улсын Нийгмийн сүлжээний тухай хуульд өгсөн санал шүүмжийг ННФ-аас эрхлэн монгол хэлнээ буулгаж хэвлэн нийтлэв.



НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

Жамъян гүний гудамж-5/1  
Сүхбаатар дүүрэг  
Улаанбаатар-14240  
Монгол Улс  
Утас: (976) 76113207  
Вэб: [www.forum.mn](http://www.forum.mn)  
И-мэйл: [osf@forum.mn](mailto:osf@forum.mn)

